

## УДШ-ИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

2024.03.29.

Улаанбаатар хот

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн

2024 оны 02 дугаар сарын 15-ны 221/МА2024/019 тоот

магадлалыг хянуулах гомдол гаргах тухай

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсэгт зааснаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны 221/МА2024/019 тоот магадлалыг Ашигт малтмалын тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн гэсэн үндэслэлээр эс зөвшөөрч, дор дурдсан гомдлыг гаргаж байна. Үүнд:

1. Давж заалдах шатны шүүх Ашигт малтмалын тухай хуулийн 22.1, 22.2, 31 дүгээр зүйлийн 31.1, 33 дугаар зүйлийн 33.1-д заасныг баримтлан “Зэмүүжин” ХХК-иас Ашигт Малтмал Газрын Тосны Газрын Геологи, Уул уурхай, Кадастрын Хэлтэст холбогдуулан гаргасан тус компаний ашигт малтмалын хайгуулын XY-018001 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахыг хариуцагчид даалгах нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

2. Анхан шатны шүүх Ашигт малтмалын тухай хуулийн 22.1, 22.2-т заасныг баримтлан нэхэмжлэгч “Зэмүүжин” ХХК-ий нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, тус компаний ашигт малтмалын хайгуулын XY-018001 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан Ашигт Малтмал Газрын Тосны Газрын Геологи, Уул уурхай, Кадастрын Хэлтсийн үйлдлийг хууль бус болохыг тогтоож, компаний хүсэлтийн дагуу тусгай зөвшөөрлийг сунгасан шийдвэр гаргахыг Ашигт Малтмал Газрын Тосны Газрын Геологи, Уул уурхай, Кадастрын Хэлтэст даалгаж шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх дээрх магадлалыг гаргахдаа Ашигт малтмалын тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг дараах байдлаар буруу тайлбарлаж хэрэглэсэн. Үүнд:

Ашигт Малтмал Газрын Тосны Газрын Геологи, Уул уурхай, Кадастрын Хэлтэс гэх захиргааны байгуулага нь “Зэмүүжин” ХХК-ний XY-018001 дугаарын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхгүй

байгаа хууль бус эс үйлдэхүй талаар гаргасан нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 834 тоот шийдвэрээр “Зэмүүжин” ХХК-ны 2021 оны 09 дугээр сарын 15-ны өдөр гаргасан хүсэлтийг шийдвэрлэхгүй байгаа хариуцагчийн эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, уг хүсэлтийг холбогдох баримтын хамт хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэхийг АМГТГ-ын ГҮҮКХэлтэст даалгаж шийдвэрлэсэн.

Энэхүү шүүхийн шийдвэрийг захиргааны байгууллага биелүүлэхээс санаатайгаар татгалзаж, шийдвэрийг биелүүлэх талаар Захиргааны Ерөнхий хуульд заасан Захиргааны шийдвэр гаргах ажиллагааг хуульд заасны дагуу явуулахын оронд хүсэлтийг холбогдох баримтын хамт хүлээн аваагүй авахаас татгалзаж, 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдөр 11/3582 тоotoor Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дугээр сарын 11-ний өдрийн 0834 тоот шийдвэрийг биелүүлж, энэхүү албан тоotoor хариу өгч байна гэж тохуурхсан үйлдэл хийсэн.

**Тодруулбал уг тоотдоо:**... 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс өмнө сунгуулах өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг ирүүлээгүй байна гэж цагаан цаасан дээр хар бэхээр өргөдөл түүнд хавсаргасан нотлох баримтыг хүлээж авахгүй байгаа захиргааны байгууллагын эс үйлдэхүй тодоос тод бичээстэй байхад давж заалдах шатны шүүх Хавсарган ирүүлэх баримт бичгийг нэхэмжлэгч ирүүлээгүй агуулгын тухайд захиргааны байгууллагыг буруутгах үндэслэлгүй гэж үнэхээр үндэслэлгүй, ойлгомжгүй дүгнэлт хийсэн.

Өөрөөр хэлбэл захиргааны байгууллага Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.2-т : ”Захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйлдэл, эс үйлдэхүйг гүйцэтгэсэн боловч шүүхээс хууль бус болохыг нь тогтоосон шийдвэрийг дахин гаргах зорилгоор өөрийн бүрэн эрхэд хамаарах эрх зүйн акт, албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг өөрчилж, нэхэмжлэгчийн эрхийг дахин зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцохгүй.” гэснийг захиргааны байгууллага зорчиж, шийдвэрийг биелүүлсэн нэр хэмээн шүүхийн хэлэлцүүлэгт хэлцэгдээд няцаагдсан үйл баримтыг иш татан тайлбарлаж шийдвэрийг биелүүлэхээс цааргалж байхад хариуцагчийн үйл ажиллагааг зөвтгөж, нэхэмжлэгчийг буруутган дүгнэсэн нь Магадлал үндэслэлгүй байх нэг үндэслэл болсон.

Давж заалдах шатны шүүх магадлалынхаа Үндэслэх хэсгийн 6.2-т : ”...нэхэмжлэгч нь Ашигт малтмалын тухай хуулийн 22.1-д заасан өргөдөлд хавсаргах бүх баримтыг ирүүлээгүй нь .....нэхэмжлэгч компаний 2023 оны 07 дугаар сарын 04-ний 07/03 албан бичигт шүүхийн шийдвэрүүдийн хуудбар, Завхан аймгийн Баянхайрхан сумын засаг даргын 2021.09.08-ны өдрийн А/87 тоот захирамжийн хуулбар, болон төлбөр төлсөн баримтын хуулбарыг хавсаргав гэж дурдсанаар тогтоогдож байхад хэрэгт ач холбогдолтой талаас нь үнэлээгүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

Захиргааны байгууллага нэхэмжлэгчийн эрхийг хязгаарласан учир шүүхээр асуудлыг шийдвэрлэж, захиргааны байгууллагад өргөдөл гаргагч хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэ гэж даалгаад байхад 2021 оны 10-р сарын 18-наас өмнө хүсэлтийг ирүүлээгүй байна гэж Захиргааны байгууллага түүний удирдах албан

тушаалтан хуульд захирагдаж шүүхийн шийдвэрийг биелүүлэхийн оронд эрх мэдэлдээ дулдуйдаж, хувийн арга барилаар бусдын эрх, ашиг сонирхлыг огт хэрэгсэхгүйгээр асуудалд хандаж байхад давж заалдах шатны шүүх энэ тухайд огт дүгнэлт хийгээгүй, хэрэгт авагдсан нотлох баримтыг хэрэгт ач холбогдолтой, хамааралтай талаас нь үнэлж чадаагүй тул Магадлал нь үндэслэлтэй бөгөөд хууль ёсны болж чадаагүй.

2. Давж заалдах шатны шүүх Магадлалдаа анхан шатны шүүх зарим баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой талаас нь бодитойгоор үнэлэлгүй, Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалтыг буруу тайлбарлан нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн нь шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн шүүх хуралдаанд нэхэмжлэгчээс Ашигт малтмалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.2, 22.1.3 заасан өргөдөлд хавсаргах баримтаас Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнөөс бусад материалыг АМГТГ-ын ГУУКХ-т хүргүүлсэн байсан ба 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн шүүх хуралдааны хэлэлцүүлэгт хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс багагүй хэмжээний ажил гүйцэтгэсэн тухай баримтыг Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан шаардахгүй байгаа тухай хариуцагч байгууллагын төлөөлөгч тайлбарласан тул давж заалдах шатны шүүх энэ баримтыг нэр заан нэхэмжлэгч бүх баримтыг ирүүлээгүй нь тогтоогдож байна гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1-р зүйлийн 1.1-д: "Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж заасан.

Хуулийн этгээдийн гаргасан өргөдөл хүсэлтийг холбогдох материалын хамт авч зохих журмын дагуу шийдвэрлэх үүрэг бүхий шийдвэрийг захиргааны байгууллага биелүүлэх талаар ямар ч ажиллагаа хийгээгүй.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д заасан "бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах" гэсэн тусгай зарчмыг захиргааны байгууллага үйл ажиллагаандaa баримталж, мөн хуулийн 26 дугаар зүйлд заасан журмын дагуу тухайн захиргааны актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоогүй нь хавтас хэрэгт авагдсан баримтуудаар нотлогдож байхад давж заалдах шатны шүүх энэ талаар дүгнэлт хийгээгүй бөгөөд энэхүү хуулийг хэрэглээгүй нь хууль хэрэглээний алдаа гэж үзэж байна.

Захиргааны байгууллагын дээрх хууль бус эс үйлдэхүйн улмаас нэхэмжлэгч “Зэмүүжин” ХХК-ний хууль ёсны эрх, ашиг сонирхол ноцтой зөрчигдөж, XY-018001 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явуулсан хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгөөр их хэмжээний хохирол амсаж байна.

Иймд анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 128/ШШ2023/0901 тоот шийдвэрийг хэвээр үлдээж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны 221/МА2024/019 тоот магадлалыг хүчингүй болгож өгнө үү.

**Харилцах утас 99292561**

**ГОМДОЛ ГАРГАСАН:**

**НЭХЭМЖЛЭГЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН  
ТӨЛӨӨЛӨГЧ**

*Б. Баатарийн*

**Б.БАЯРМАА**